<b>XIII</b>	<b>ҮЙЛДВЭР, ХӨДӨӨ АЖ АХУЙН САЙД</b>			<b>22,347.1</b>	<b>6,578.6</b>
<b>XIII.1</b>	<b>I.Хөрөнгө оруулалт</b>			<b>21,347.1</b>	<b>6,072.6</b>
	Шилжих			21,347.1	6,072.6
XIII.1.1	Малын удмын сангийн үндэсний цогцолбор /Дархан-Уул, Хонгор сум/	2012	2015	12,271.0	2,000.0
XIII.1.2	Буянт голын услалтын систем /Хөвд/	2013	2015	2,224.8	371.3



XIII.1.3	Хөнгөн үйлдвэрийн салбарт нано биотехнологи нутагшуулах	2012	2015	500.0	500.0
XIII.1.4	Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрийн цэвэрлэх байгууламж /Ховд/	2012	2016	5,000.0	2,500.0
XIII.1.5	Мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн барилга /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/	2013	2015	1,351.3	701.3
<b>XIII.5</b>	<b>V.Хөрөнгийн шилжүүлэг, дэмжлэг</b>			<b>1,000.0</b>	<b>506.0</b>
	Шилжих			<b>1,000.0</b>	<b>506.0</b>
XIII.5.1	Хүнсний ногооны хүлэмжийн аж ахуй байгуулах	2012	2015	1,000.0	506.0
<b>XIV</b>	<b>ХӨДӨЛМӨРИЙН САЙД</b>			<b>38,745.4</b>	<b>14,912.3</b>
<b>XIV.1</b>	<b>Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэл</b>			<b>27,814.0</b>	<b>10,927.0</b>
<b>XIV.1.1</b>	<b>I.Хөрөнгө оруулалт</b>			<b>27,814.0</b>	<b>10,927.0</b>
	Шилжих			27,814.0	10,927.0
XIV.1.1.1	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн дотуур байр, 120 ор /Дорноговь/	2013	2015	1,439.7	719.8
XIV.1.1.2	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн хичээлийн байр /Дорнод, Хэрлэн сум/	2013	2015	4,149.0	2,074.5
XIV.1.1.3	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн дотуур байр /Орхон/	2013	2015	2,247.2	1,123.6
XIV.1.1.4	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн хичээлийн байр, дадлагын байр, спорт заал, 960 суудал /Дундговь, Сайнцагаан сум/	2012	2015	6,738.0	994.9
XIV.1.1.5	Хөдөө аж ахуйн их сургуулийн Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн хичээлийн байр /Орхон/	2013	2015	2,162.0	1,081.0



XIY.1.1.6	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн дотуур байрын барилга, 200 ор /Дундговь, Сайнцагаан сум/	2012	2015	2,281.8	1,140.9
XIY.1.1.7	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн биеийн тамирын заалын барилга /Өмнөговь/	2013	2015	654.0	500.0
XIY.1.1.8	Политехникийн коллежийн хотхон /Дорнод, Хэрлэн сум/	2014	2015	2,000.0	1,000.0
XIY.1.1.9	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн хичээлийн байр, спорт заалын барилга, 320 суудал /Завхан, Тосонцэнгэл сум/	2014	2015	5,409.3	1,559.3
XIY.1.1.10	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн биеийн тамирын заалын барилга /Архангай/	2013	2015	733.0	733.0
<b>XIY.2</b>	<b>Жижиг, дунд үйлдвэрлэл</b>			<b>10,931.4</b>	<b>3,985.3</b>
<b>XIY.2.1</b>	<b>I.Хөрөнгө оруулалт</b>			<b>10,931.4</b>	<b>3,985.3</b>
	Шилжих			10,931.4	3,985.3
XIY.2.1.1	Хүнс, барааны худалдааны төв /Хөвсгөл, Мөрөн сум/	2012	2015	4,200.0	1,908.0
XIY.2.1.2	Худалдааны төвийн барилга /Сэлэнгэ, Сүхбаатар сум/	2012	2015	3,000.0	750.0
XIY.2.1.3	Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төв /Баянхонгор, Баянхонгор сум/	2011	2015	2,970.0	1,109.6
XIY.2.1.4	Ахуй үйлчилгээний төвийн барилга /Ховд, Жаргалант сум/	2011	2015	761.4	217.7
<b>XУ</b>	<b>ХҮН АМЫН ХӨГЖИЛ, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД</b>			<b>27,949.6</b>	<b>14,386.9</b>
<b>XУ.1</b>	<b>Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам</b>			<b>14,049.6</b>	<b>7,336.9</b>



ХҮ.1.1	<b>I.Хөрөнгө оруулалт</b>			<b>14,049.6</b>	<b>7,336.9</b>
	Шилжих			14,049.6	7,336.9
ХҮ.1.1.1	Батсүмбэрийн Ахмадын асрамж, хөгжлийн үндэсний төвийн нөхөн сэргээх сувиллын барилга /Төв, Батсүмбэр сум/	2014	2015	5,591.1	3,000.0
ХҮ.1.1.2	Батсүмбэрийн Ахмадын асрамж, хөгжлийн үндэсний төвийн байрын өргөтгөл /Төв, Батсүмбэр сум/	2014	2015	3,398.5	1,699.2
ХҮ.1.1.3	Нийслэлийн нийгмийн даатгалын газар, нийслэлийн нийгмийн халамж, үйлчилгээний газрын барилга, тохижилт, тоног төхөөрөмжийн хамт /Нийгмийн даатгалын сангийн эх үүсвэрээс хамтран санхүүжүүлэх /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/	2014	2016	2,000.0	1,000.0
ХҮ.1.1.4	Ахмадын ордны барилга /Орхон, Баян-Өндөр сум/	2014	2015	750.0	350.0
ХҮ.1.1.5	Ахмадын болон амьдрах ухааны ордон /Завхан, Улиастай сум/	2014	2015	1,200.0	600.0
ХҮ.1.1.6	Ахмадын сувиллын барилга /Увс, Улаангом сум/	2012	2015	400.0	400.0
ХҮ.1.1.7	Ахмадын сувиллын газрын барилга /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/	2010	2015	710.0	287.7
<b>ХҮ.2</b>	<b>Хүүхдийн төлөө үндэсний газар</b>			<b>13,900.0</b>	<b>7,050.0</b>
<b>ХҮ.2.1</b>	<b>I.Хөрөнгө оруулалт</b>			<b>13,900.0</b>	<b>7,050.0</b>
	Шилжих			13,900.0	7,050.0
ХҮ.2.1.1	Усан спорт цогцолбор /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, Найрамдал зуслан/	2014	2016	9,600.0	4,100.0



ХҮ.2.1.2	Баянгол хүүхдийн зуслангийн цогцолбор /Улаанбаатар, Налайх дүүрэг/	2013	2016	4,300.0	2,950.0
<b>ХҮИ</b>	<b>ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД</b>			<b>137,032.0</b>	<b>57,625.4</b>
<b>ХҮИ.1</b>	<b>I.Хөрөнгө оруулалт</b>			<b>111,197.1</b>	<b>36,103.5</b>
	Шилжих			111,197.1	36,103.5
ХҮИ.1.1	Халдварт өвчин судлалын үндэсний төвийн III шатлалын лабораторийн барилга /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/	2013	2016	20,000.0	6,750.0
ХҮИ.1.2	Гэмтэл, согог судлалын үндэсний төвийн харьяа Түлэнхийн төвийн барилга /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/	2013	2017	26,000.0	5,514.5
ХҮИ.1.3	Аймгийн нэгдсэн эмнэлгийн өргөтгөлийн барилга /Хэнтий, Хэрлэн сум/	2012	2016	12,450.9	4,226.5
ХҮИ.1.4	Хавдар судлалын үндэсний төвийн өргөтгөл /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/	2010	2016	5,597.4	3,108.6
ХҮИ.1.5	Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа “Эрүүл мэндийн хөгжил хөтөлбөр-5”	2013	2018	4,613.1	1,000.0
ХҮИ.1.6	Хүүхдийн эмнэлгийн барилга /Орхон, Баян-Өндөр сум/	2012	2015	1,200.0	1,200.0
ХҮИ.1.7	Улсын клиникийн төв эмнэлгийн өргөтгөлийн Б блокын барилгын зураг, төслийн санхүүжилт /Улаанбаатар/	2012	2015	492.2	492.2
ХҮИ.1.8	Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн өргөтгөл /Орхон/	2012	2015	2,300.0	2,300.0





ХҮ1.1.9	Эмнэлгийн барилга, 14 ор /Баянхонгор, Баянцагаан сум/	2013	2015	1,013.4	1,013.4
ХҮ1.1.10	Бельгийн хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа "Баруун бүсийн эмчилгээ, оношилгооны төвийг сайжруулах" төсөл	2013	2017	8,700.0	1,000.0
ХҮ1.1.11	Эрүүл мэндийг дэмжих төв /Сүхбаатар, Баруун-Урт сум/	2012	2015	1,379.1	780.8
ХҮ1.1.12	Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн барилга /Улаанбаатар/	2013	2015	2,949.9	600.0
ХҮ1.1.13	Эмнэлгийн барилга, 10 ор /Завхан, Асгат сум/	2013	2015	1,014.6	600.0
ХҮ1.1.14	Сумын эрүүл мэндийн төв, 10 ор /Баянхонгор, Шаргалжуут сум/	2014	2015	1,112.7	532.7
ХҮ1.1.15	Сумын эрүүл мэндийн төв, 10 ор /Баянхонгор, Баянбулаг сум/	2014	2015	1,112.7	512.7
ХҮ1.1.16	Эмнэлгийн барилга, 10 ор /Дундговь, Адаацаг сум/	2013	2015	861.1	500.0
ХҮ1.1.17	Байгалийн голомтот халдварт өвчинтэй тэмцэх газрын барилга /Хэнтий, Хэрлэн сум/	2013	2015	618.5	500.0
ХҮ1.1.18	Сувиллын барилга, тоног төхөөрөмжийн шинэчлэл /Дорноговь, Эрдэнэ сум, "Бүрдэнэбулаг" бөөрний сувилал/	2014	2015	1,000.0	467.4
ХҮ1.1.19	Эрүүл мэндийн төв /Хөвсгөл, Бүрэнтогтох сум/	2014	2015	1,315.8	765.8
ХҮ1.1.20	Төрөх эмнэлгийн барилга, 50 ор /Дорнод, Хэрлэн сум/	2012	2015	2,774.0	450.0



ХҮҮ.1.21	Эрүүл мэндийг дэмжих төв /Архангай, Эрдэнэбулган сум/	2012	2015	895.1	384.0
ХҮҮ.1.22	Хүн эмнэлгийн барилга, 20 ор /Архангай, Тариат сум/	2013	2015	1,174.7	16.5
ХҮҮ.1.23	Эмнэлгийн барилга /Дорнод, Хэрлэн сум, 4 дүгээр баг/	2014	2015	705.0	355.0
ХҮҮ.1.24	Эмнэлгийн барилга, 10 ор /Өвөрхангай, Бүрд сум/	2012	2015	798.0	350.2
ХҮҮ.1.25	Төрөх эмнэлэг, 50 ор /Говь-Алтай, Есөнбулаг сум/	2011	2015	2,898.9	1,009.8
ХҮҮ.1.26	Халдвартын эмнэлгийн барилга, 30 ор /Завхан, Улиастай сум/	2011	2015	1,759.3	313.3
ХҮҮ.1.27	Эрүүл мэндийг дэмжих төв /Дундговь, Сайнцагаан сум/	2012	2015	759.2	307.8
ХҮҮ.1.28	Өрхийн эмнэлгийн барилга /Говь-Алтай, Есөнбулаг сум, Энх-Алтай өрхийн эмнэлэг/	2014	2015	544.9	94.9
ХҮҮ.1.29	Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн халдвартын эмнэлгийн барилга /Өвөрхангай, Арвайхээр сум/	2014	2015	2,133.0	233.0
ХҮҮ.1.30	Эмнэлгийн барилга, 15 ор /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, Хонхор тосгон/	2012	2015	773.2	196.0
ХҮҮ.1.31	Эмнэлгийн барилга, 10 ор /Архангай, Өгийнуур сум/	2011	2015	399.2	62.8
ХҮҮ.1.32	Уламжлалт анагаах ухааны эмнэлгийн барилга, 20 ор /Дорнод, Хэрлэн сум/	2011	2015	637.2	131.0
ХҮҮ.1.33	Эмнэлгийн амбулаторийн барилга /Булган, Хутаг-Өндөр сум/	2012	2015	1,214.0	334.6
<b>ХҮҮ.2</b>	<b>II. Их засвар</b>			<b>7,334.1</b>	<b>7,334.1</b>
	Шинэ			7,334.1	7,334.1



ХҮ1.2.1	Харьяа газрын засвар /улсын хэмжээнд/	2015	2015	2,966.7	2,966.7
ХҮ1.2.2	Нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудын их засвар /Улаанбаатар/	2015	2015	846.2	846.2
ХҮ1.2.3	Аймаг, сумын эмнэлгийн эрүүл мэндийн байгууллагуудын их засвар /улсын хэмжээнд/	2015	2015	3,521.2	3,521.2
<b>ХҮ1.3</b>	<b>III.Тоног төхөөрөмж</b>			<b>18,500.7</b>	<b>14,187.7</b>
	Шилжих			3,651.5	910.0
ХҮ1.3.1	Аймгуудын эрүүл мэндийн газрын түргэн тусламжийн автомашин, тоног төхөөрөмж, засвар /Дархан-Уул, сумд; Сэлэнгэ, Баянгол сум/	2014	2016	1,000.0	350.0
ХҮ1.3.2	Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн тоног төхөөрөмж /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/	2014	2016	2,651.5	560.0
	Шинэ			14,849.2	13,277.7
	<b>Аймаг, нийслэл</b>			<b>4,741.3</b>	<b>4,741.3</b>
ХҮ1.3.3	Аймгуудын Эрүүл мэндийн газар, Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, Нэгдсэн эмнэлгийн тоног төхөөрөмж /улсын хэмжээнд/	2015	2015	1,050.0	1,050.0
ХҮ1.3.4	Аймгуудын Зооноз өвчин судлалын төв, Уламжлалт анагаах ухааны төвийн тоног төхөөрөмж /улсын хэмжээнд/	2015	2015	406.0	406.0
ХҮ1.3.5	Аймгуудын сум, өрхийн эрүүл мэндийн төвийн тоног төхөөрөмж /улсын хэмжээнд/	2015	2015	1,045.3	1,045.3



ХҮ1.3.6	Нийслэл, дүүргүүдийн эрүүл мэндийн байгууллагуудын тоног төхөөрөмж /Улаанбаатар/	2015	2015	840.0	840.0
ХҮ1.3.7	Аймаг, дүүрэг, сум, өрхийн эмнэлгүүдийг телемедицины сүлжээнд холбох /улсын хэмжээнд/	2015	2015	350.0	350.0
ХҮ1.3.8	Аймаг, дүүргийн эмнэлгүүдийн эмчилгээний ор хэрэгсэл, шинэчлэл /улсын хэмжээнд/	2015	2015	1,050.0	1,050.0
	<b>Харьяа байгууллага</b>			<b>10,107.9</b>	<b>8,536.4</b>
ХҮ1.3.9	Халдварт өвчин судлалын үндэсний төвийн тоног төхөөрөмж /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/	2015	2015	700.0	700.0
ХҮ1.3.10	Геронтологийн үндэсний төвийн тоног төхөөрөмж /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/	2015	2015	31.4	31.4
ХҮ1.3.11	Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн тоног төхөөрөмж /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/	2015	2015	175.8	175.8
ХҮ1.3.12	Эмгэг судлалын үндэсний төвийн тоног төхөөрөмж /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/	2015	2015	609.6	609.6
ХҮ1.3.13	Зоонозын өвчин судлалын төвийн тоног төхөөрөмж /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/	2015	2015	649.7	649.7
ХҮ1.3.14	Гэмтэл, согог судлалын үндэсний төвийн тоног төхөөрөмж /Улаанбаатар, Баянгол дүүрэг/	2015	2015	1,050.0	1,050.0



ХҮИ.3.15	Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн тоног төхөөрөмж /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/	2015	2015	700.0	700.0
ХҮИ.3.16	Эрүүл мэндийн байгууллагуудын түргэн тусламжийн автомашин /улсын хэмжээнд/	2015	2016	3,111.5	1,540.0
ХҮИ.3.17	Эмийн аюулгүй байдлын мэдээллийн системийг сайжруулах /улсын хэмжээнд/	2015	2015	980.0	980.0
ХҮИ.3.18	Зүрх судасны тусламж үйлчилгээний тоног төхөөрөмж /Улаанбаатар, Баянгол дүүрэг/	2015	2015	1,050.0	1,050.0
ХҮИ.3.19	Төв эмнэлгүүдийн эмчилгээний ор хэрэгсэл, багаж шинэчлэл /Улаанбаатар/	2015	2015	1,050.0	1,050.0
<b>ХҮИ</b>	<b>УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР</b>			<b>7,919.3</b>	<b>2,941.6</b>
<b>ХҮИ.1</b>	<b>I.Хөрөнгө оруулалт</b>			<b>7,919.3</b>	<b>2,941.6</b>
	Шилжих			7,919.3	2,941.6
ХҮИ.1.1	Аймгийн прокурорын газрын конторын барилга /Баян-Өлгий, Өлгий сум/	2013	2015	1,000.0	702.9
ХҮИ.1.2	Улсын ерөнхий прокурорын газрын архивын барилга /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/	2012	2015	873.7	538.7
ХҮИ.1.3	Сум дундын прокурорын конторын барилга /Өмнөговь, Ханбогд сум/	2013	2015	758.6	200.0
ХҮИ.1.4	Улсын ерөнхий прокурорын газрын сургалтын төвийн барилга /Сэлэнгэ, Мандал сум/	2013	2015	5,287.0	1,500.0
	<b>НИЙТ</b>			<b>1,800,111.9</b>	<b>655,417.5</b>



Монгол Улсын 2015 оны төсвийн тухай  
хуулийн 3 дугаар хавсралт

**ХӨГЖЛИЙН БАНКНЫ ЭХ ҮҮСВЭРЭЭР, ТӨСВӨӨС ЭРГЭН  
ТӨЛӨГДӨХ НӨХЦӨЛТЭЙГӨӨР 2015 ОНД САНХҮҮЖҮҮЛЭХ  
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ,  
БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЖАГСААЛТ**

*/сая төгрөгөөр/*

Дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	2015 онд санхүүжих дүн
		Эхлэх	Дуусах		
I	<b>УУЛ УУРХАЙ, ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД</b>			<b>82,526.1</b>	<b>58,487.2</b>
I.1	<b>I. Хөрөнгө оруулалт</b>			<b>82,526.1</b>	<b>58,487.2</b>
I.1.1	Гэр хорооллын хүчдэлийн уналттай болон шинэ суурьшлын бүсийн гэр хорооллын айл өрхийг цахилгаан хангамжаар хангах /Улаанбаатар/	2014	2015	9,000.0	6,500.0
I.1.2	Залаат, Бага тэнгэр, Их тэнгэрийн ам, Хан-Уул, Баянзүрх дүүргийн хорооллуудын цахилгаан хангамжийг сайжруулах зорилгоор 110/10 кВ-ын дэд станц, 110 кВ-ын 7.6 км цахилгаан дамжуулах агаарын шугам /Улаанбаатар/	2014	2015	8,969.3	4,469.3
I.1.3	Баруун-Урт-Асгат-Эрдэнэцагааны 35 кВ-ын 197 км цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц, 110/35/6 кВ-ын дэд станцын өргөтгөл /Сүхбаатар/	2014	2015	8,400.0	5,400.0
I.1.4	Хорооллын гадны цахилгаан хангамж 6/0.4 кВ-ын 2х630 кВа ХТП-15 ком, 6кВ-ын 34,9 км кабель шугам /Дархан-Уул, Дархан сум, 11, 12, 24, 25, 26 дугаар хороолол/	2014	2015	9,715.0	6,215.0



I.1.5	Хорооллын гадны цахилгаан хангамж 6/0.4 кВ-ын 2х630 кВа ХТП-8 ком, 6 кВ-ын 10,5 км кабель шугам /Дархан-Уул, Дархан сум, 2, 3 дугаар хороолол/	2014	2015	4,969.0	3,469.0
I.1.6	Томоохон баг, суурин газруудыг эрчим хүчээр хангах, сумдын 0.4 кВ-ын өргөтгөл, шинэчлэлт /улсын хэмжээнд/	2014	2015	17,000.0	12,000.0
I.1.7	Мардай-Чулуунхороот сумын 35 кВ-ын 160 км цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц /Дорнод/	2012	2015	4,397.4	3,358.5
I.1.8	Дарханы дулааны цахилгаан станцад хаягдал үнсэн сан шинээр барих /Дархан-Уул/	2014	2015	8,147.5	5,147.5
I.1.9	Эрчим хүчний төвлөрсөн системд холбох, 3 сум /Дорноговь, Хатанбулаг, Мандах сум, Говь-Алтай, Бугат сум/	2015	2015	11,928.0	11,928.0
<b>II</b>	<b>ЗАМ, ТЭЭВЭР, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД</b>			<b>370,915.1</b>	<b>129,069.6</b>
<b>II.1</b>	<b>I. Хөрөнгө оруулалт</b>			<b>369,215.1</b>	<b>127,369.6</b>
II.1.1	Үндэсний орон зайн мэдээллийн дэд бүтцийн суурь мэдээллийг бий болгох /улсын хэмжээнд/	2012	2016	15,000.0	4,455.0
II.1.2	Инженерийн шугам сүлжээ /Хэнтий, Хэрлэн сум/	2014	2015	4,374.3	2,124.3
II.1.3	Цэвэр, бохир усны шугам сүлжээ, усан сан, насосны станц, цэвэрлэх байгууламжийн өргөтгөл, шинэчлэлт /Улаанбаатар, Багахангай дүүрэг/	2013	2015	7,600.0	5,600.3



II.1.4	Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжид 2 дугаар тунгаагуур 2 ширхэг, биоцөөрөм барих /Улаанбаатар, Баянгол дүүрэг/	2013	2015	8,519.1	4,135.3
II.1.5	Аймгийн төвийн 1000 айлын орон сууцны хорооллын инженерийн шугам сүлжээ /Баянхонгор, Дорноговь, Төв, Говьсүмбэр, Булган, Увс, Хөвсгөл, Дархан-Уул, Орхон, Сүхбаатар, Өвөрхангай, Өмнөговь, Хэнтий/	2013	2017	62,000.0	9,604.8
II.1.6	Сумын төвийн шинэчлэл төсөл /Архангай, Баян-Өлгий, Булган, Говь-Алтай, Өвөрхангай, Дорнод, Дундговь, Завхан, Сүхбаатар, Сэлэнгэ, Өмнөговь, Төв, Увс, Ховд, Хэнтий, Хөвсгөл аймагт тус бүр нэг сум/	2014	2016	80,000.0	19,877.7
II.1.7	Элсэн тасархай-Хархорины Орхоны гүүр чиглэлийн 77 км хатуу хучилттай авто замын шинэчлэл /Өвөрхангай/	2012	2015	26,965.1	17,020.2
II.1.8	Ханх-Мондын чиглэлийн 23 км хатуу хучилттай авто зам /Хөвсгөл, Ханх сум/	2012	2015	14,340.4	9,352.0
II.1.9	Мөрөн сумын дунд тойргийн 9.8 км хатуу хучилттай авто замын өргөтгөл /Хөвсгөл, Мөрөн сум/	2012	2015	8,300.0	3,000.0
II.1.10	Олон улсын шинэ нисэх буудал барихтай холбогдуулан монголын талын гүйцэтгэх төсөл, арга хэмжээ /Төв, Сэргэлэн сум, Хөшигийн хөндий/	2012	2016	122,874.2	38,000.0





II.1.11	Гүүр, 4 ширхэг /Сэлэнгэ мөрний төмөр бетон 422.5 у/м гүүр, Сэлэнгэ мөрний дөрөө хангинахын хөвдөг гүүр, Дэлгэрмөрөн голын хөвдөг гүүр, Бирваазын шинэчлэл, Ерөө голын төмөр бетон гүүр/ /Булган, Сэлэнгэ, Хөвсгөл аймгийн Баянзүрх, Их-Уул сум/	2013	2015	19,242.0	14,200.0
II.4	<b>IV. Техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл</b>			<b>1,700.0</b>	<b>1,700.0</b>
II.4.1	Аймгийн төвөөс хилийн боомтууд чиглэлийн хатуу хучилттай авто замуудын техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах /Дорнод, Хэрлэн сум, Баянхошуу боомт, Хавиргын боомт, Ульхан боомт/	2015	2015	1,700.0	1,700.0
III	<b>ҮЙЛДВЭР, ХӨДӨӨ АЖ АХУЙН САЙД</b>			<b>16,000.0</b>	<b>8,000.0</b>
III.1	<b>I. Хөрөнгө оруулалт</b>			<b>16,000.0</b>	<b>8,000.0</b>
III.1.1	Газар тариалангийн бүтээгдэхүүний агуулах /Дархан-Уул, Дархан сум/	2014	2015	16,000.0	8,000.0
	<b>НИЙТ</b>			<b>469,441.2</b>	<b>195,556.8</b>

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2014 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр

Улаанбаатар хот

**ХҮНИЙ ХӨГЖИЛ САНГИЙН 2015 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ**

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

**1 дүгээр зүйл.Хуулийн зорилт**

1.1.Энэ хуулийн зорилт нь Хүний хөгжил санд 2015 оны төсвийн жилд төвлөрүүлэх орлого, тус сангаас зарцуулах хөрөнгийн хэмжээ,



эрсдэлийн нөөц хөрөнгийн хэмжээ, төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр, мөнгөн гүйлгээтэй холбогдох хязгаарлалтыг тогтоох, зарцуулах эрх олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

## 2 дугаар зүйл. Хүний хөгжил сангийн 2015 оны төсвийн тухай хууль тогтоомж

2.1. Хүний хөгжил сангийн 2015 оны төсвийн тухай хууль тогтоомж нь Төсвийн тухай хууль<sup>1</sup>, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль<sup>2</sup>, Хүний хөгжил сангийн тухай хууль<sup>3</sup>, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

### ХОЁРДУГААР БҮЛЭГ ХҮНИЙ ХӨГЖИЛ САНГИЙН 2015 ОНЫ ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, ХӨРӨНГӨ, ӨР ТӨЛБӨР, ЭРСДЭЛИЙН НӨӨЦ ХӨРӨНГӨ

3 дугаар зүйл. Хүний хөгжил сангийн төсөвт 2015 оны төсвийн жилд төвлөрүүлэх төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээг 526,294.5 сая төгрөгөөр, төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харьяа байгууллагын төвлөрүүлэх орлогын хэмжээг доор дурдсанаар баталсугай:

Д/д	Төсвийн ерөнхийлөн захирагч	Дүн /сая төгрөгөөр/
1	<b>Сангийн сайд</b>	456,294.5
	1.1. Татварын ерөнхий газар	456,294.5
	1.1.1. Хүний хөгжил сангийн тухай хуулийн 3.2.2-т заасан орлого	456,294.5
2	<b>Монгол Улсын Ерөнхий сайд</b>	70,000.0
	2.1. Төрийн өмчийн хороо	70,000.0
	2.1.1. Хүний хөгжил сангийн тухай хуулийн 3.2.1-д заасан орлого	70,000.0

4 дүгээр зүйл. Хүний хөгжил сангийн төсвөөс 2015 оны төсвийн жилд зарцуулах төсвийн зарлагын хэмжээг 342,325.4 сая төгрөгөөр баталж, төсвийн ерөнхийлөн захирагч нарт доор дурдсан төсөв зарцуулах эрхийг олгосугай:

<sup>1</sup>Төсвийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2012 оны 03 дугаарт нийтлэгдсэн.

<sup>2</sup>Төсвийн тогтвортой байдлын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2010 оны 30 дугаарт нийтлэгдсэн.

<sup>3</sup>Хүний хөгжил сангийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2009 оны 45 дугаарт нийтлэгдсэн.



Д/д	Төсвийн ерөнхийлөн захирагч	Дүн /сая төгрөгөөр/
1	<b>Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд</b>	263,045.9
	1.1.Төр хариуцан төлөх эрүүл мэндийн даатгалын шимтгэл	12,040.2
	1.2.Хүүхдийн мөнгө	246,000.0
	1.3.Хөрөнгө оруулалт	5,005.7
2	<b>Сангийн сайд</b>	316,239.5
	2.1.Засгийн газрын бонд болон урьдчилгаа төлбөрийн хүүгийн зардал	79,279.5
	2.2.Урьдчилгаа мөнгө, зээлийн үндсэн төлбөрт төлөгдөх цэвэр дүн	78,260.0
	2.2.1.Нийт төлөх	167,800.0
	2.2.2.Улсын төсвийн орлогод хаагдсан урьдчилгаа төлбөрийн дүнгээр улсын төсөвт өгөх өглөг	89,540.0
	2.3.Засгийн газрын бондын үндсэн төлбөрт	158,700.0
	2.4.Эрсдэлийн нөөц хөрөнгө	0.0

**5 дугаар зүйл.**Хүний хөгжил санд 2015 оны төсвийн жилд хуримтлуулах мөнгөн хөрөнгийн хэмжээг 0.0 төгрөг байхаар баталсугай.

**6 дугаар зүйл.**“Хүний хөгжил сангийн хөрөнгөөр 2015 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт”-ыг хавсралтаар баталсугай.

**ГУРАВДУГААР БҮЛЭГ  
БУСАД ЗҮЙЛ**

**7 дугаар зүйл.**Энэ хуулийг 2015 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**



Хүний хөгжил сангийн 2015 оны төсвийн  
тухай хуулийн хавсралт

**ХҮНИЙ ХӨГЖИЛ САНГИЙН ХӨРӨНГӨӨР 2015 ОНД  
САНХҮҮЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ,  
АРГА ХЭМЖЭЭ, БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЖАГСААЛТ**

/сая төгрөгөөр/

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр, байршил	Эхлэх, дуусах хугацаа	Төсөвт өртөг	2015 онд санхүүжих
	<b>Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд</b>		<b>5,005.7</b>	<b>5,005.7</b>
1.	<b>Хөрөнгө оруулалт</b>		<b>5,005.7</b>	<b>5,005.7</b>
1.1	Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хэлтсийн барилга, тоног төхөөрөмжийн хамт /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/	2015-2015	1,668.6	1,668.6
1.2	Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хэлтсийн барилга, тоног төхөөрөмжийн хамт /Улаанбаатар, Баянгол дүүрэг/	2015-2015	1,668.6	1,668.6
1.3	Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хэлтсийн барилга, тоног төхөөрөмжийн хамт /Архангай, Хайрхан сум/	2015-2015	1,668.6	1,668.6

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2014 оны 11 дүгээр  
сарын 14-ний өдөр

Улаанбаатар  
хот

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН  
2015 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ**

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ  
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

**1 дүгээр зүйл.Хуулийн зорилт**

1.1.Энэ хуулийн зорилт нь Нийгмийн даатгалын санд 2015 оны төсвийн жилд төвлөрүүлэх орлого, зарцуулах төсвийн хэмжээ, төсөв зарцуулах эрх олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.



## **2 дугаар зүйл.Нийгмийн даатгалын сангийн 2015 оны төсвийн тухай хууль тогтоомж**

2.1.Нийгмийн даатгалын сангийн 2015 оны төсвийн тухай хууль тогтоомж нь Төсвийн тухай хууль<sup>1</sup>, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль<sup>2</sup>, Нийгмийн даатгалын тухай хууль<sup>3</sup>, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

### **ХОЁРДУГААР БҮЛЭГ НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2015 ОНЫ ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА**

**3 дугаар зүйл.**Нийгмийн даатгалын санд 2015 оны төсвийн жилд Төсвийн ерөнхийлөн захирагчдын төвлөрүүлэх орлогын хэмжээг доор дурдсанаар баталсугай:

<b>Д/д</b>	<b>Орлогын төрөл</b>	<b>Дүн /сая төгрөгөөр/</b>
<b>1</b>	<b>Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд</b>	<b>1,452,684.7</b>
	1.1.Аж ахуйн нэгж, байгууллагаас төлөх шимтгэл	587,801.8
	1.2.Ажиллагсдаас төлөх шимтгэл	607,456.4
	1.3.Төсөвт байгууллагаас төлөх шимтгэл	174,765.7
	1.4.Нөхөн олговор авагчийн нийгмийн даатгалын шимтгэл	0.6
	1.5.Хүний хөгжил сангаас төлөх иргэний эрүүл мэндийн даатгалын шимтгэл	12,040.2
	1.6.Сайн дурын даатгуулагчаас төлөх шимтгэл	37,570.3
	1.7.Эрүүл мэндийн даатгалын бусад даатгуулагчийн төлөх шимтгэл	4,654.1
	1.8.Гадаадад хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа иргэдийн төлөх шимтгэл	1,800.0
	1.9.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон даатгуулагчийн төлөх шимтгэл	1,101.7
1.10.Бусад орлого	25,493.9	
<b>2</b>	<b>Сангийн сайд</b>	<b>320,131.3</b>
	2.1.Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг	320,131.3
<b>Нийт орлого</b>		<b>1,772,816.0</b>

<sup>1</sup>Төсвийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2012 оны 03 дугаарт нийтлэгдсэн.

<sup>2</sup>Төсвийн тогтвортой байдлын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2010 оны 30 дугаарт нийтлэгдсэн.

<sup>3</sup>Нийгмийн даатгалын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1994 оны 08 дугаарт нийтлэгдсэн.



**4 дүгээр зүйл.**Нийгмийн даатгалын сангийн 2015 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчид доор дурдсан төсөв зарцуулах эрх олгосугай:

Д/д	Зарлагын төрөл	Дүн /сая төгрөгөөр/
1	<b>Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд</b>	
	1.1.Тэтгэврийн даатгалын сан	1,098,227.5
	1.2.Тэтгэмжийн даатгалын сан	78,477.4
	1.3.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сан	35,509.8
	1.4.Ажилгүйдлийн даатгалын сан	19,109.9
	1.5.Эрүүл мэндийн даатгалын сан	219,390.0
	1.6.Шүүхийн шийдвэр биелүүлэх албаны төлбөр	118.8
	1.7.Үйл ажиллагааны урсгал зардал	20,698.2
	1.8.Хөрөнгийн зардал	13,429.3
<b>Нийт зарлага</b>		<b>1,484,960.9</b>

**ГУРАВДУГААР БҮЛЭГ  
БУСАД ЗҮЙЛ**

**5 дугаар зүйл.**"Нийгмийн даатгалын сангийн хөрөнгөөр 2015 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт"-ыг хавсралтаар баталсугай.

**6 дугаар зүйл.**Нийгмийн даатгалын сангийн хуримтлалын сангаас Засгийн газрын урт хугацаат (нэг жил болон түүнээс дээш) бонд худалдан авахад зарцуулах хөрөнгийн дээд хэмжээг 400,000.0 сая төгрөгөөр баталсугай.

**7 дугаар зүйл.**Энэ хуулийг 2015 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**



Нийгмийн даатгалын сангийн 2015 оны  
төсвийн тухай хуулийн хавсралт

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ХӨРӨНГӨӨР 2015 ОНД  
САНХҮҮЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА  
ХЭМЖЭЭ, БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЖАГСААЛТ**

*/сая төгрөгөөр/*

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	2015 онд санхүүжих
		Эхлэх	Дуусах		
	<b>Нийгмийн даатгалын ерөнхий газар</b>			<b>16,474.8</b>	<b>13,429.3</b>
<b>1</b>	<b>I.Хөрөнгө оруулалт</b>			<b>11,790.4</b>	<b>8,744.9</b>
1.1	Шилжих			3,221.8	1,669.6
1.1.1	Нийгмийн даатгалын хэлтсийн барилга /Улаанбаатар, Налайх дүүрэг/	2014	2015	1,001.4	484.0
1.1.2	Нийгмийн даатгалын хэлтсийн барилга /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/	2014	2015	1,400.0	882.6
1.1.3	Нийгмийн даатгалын тасгийн барилга /Улаанбаатар, Баянгол дүүрэг/	2014	2015	820.4	303.0
1.2	Шинэ			8,568.6	7,075.3
1.2.1	Нийгмийн даатгалын хэлтсийн барилга /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/	2015	2015	1,400.0	1,400.0
1.2.2	Нийгмийн даатгалын тасгийн барилга /Архангай, Хайрхан сум/	2015	2015	820.4	820.4
1.2.3	Нийгмийн даатгалын тасгийн барилга /Ховд, Булган сум/	2015	2015	337.8	337.8
1.2.4	Нийгмийн даатгалын тасгийн барилга /Өмнөговь, Ханбогд сум/	2015	2015	817.4	817.4
1.2.5	Нийгмийн даатгалын тасгийн барилга /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/	2015	2015	820.4	820.4



1.2.6	Нийгмийн даатгалын тасгийн барилга /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/	2015	2015	820.4	820.4
1.2.7	Нийгмийн даатгалын тасгийн барилга /Сэлэнгэ, Алтанбулаг сум/	2015	2015	820.4	820.4
1.2.8	Нийгмийн даатгалын хэлтсийн барилга /Дархан-Уул, Дархан сум/	2015	2016	1,807.8	314.5
1.2.9	Нийгмийн даатгалын хэлтсийн барилгын өргөтгөл /Ховд, Жаргалант сум/	2015	2015	730.9	730.9
1.2.10	Актлагдсан барилгын буулгах зардал /Улаанбаатар, Баянгол дүүрэг/	2015	2015	116.9	116.9
1.2.11	Актлагдсан барилгын буулгах зардал /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/	2015	2015	76.2	76.2
<b>2</b>	<b>II.Их засвар</b>			<b>1,095.3</b>	<b>1,095.3</b>
2.1	Шинэ			1,095.3	1,095.3
2.1.1	Нийгмийн даатгалын хэлтсийн барилгын их засвар /Баянхонгор, Баянхонгор сум/	2015	2015	210.0	210.0
2.1.2	Нийгмийн даатгалын хэлтсийн барилгын их засвар /Баян-Өлгий, Өлгий сум/	2015	2015	51.1	51.1
2.1.3	Нийгмийн даатгалын хэлтсийн дээврийн их засвар /Завхан, Тосонцэнгэл сум/	2015	2015	51.1	51.1
2.1.4	Нийгмийн даатгалын тасгийн барилгын гадна хашаа хайс барих /Өмнөговь, Цогтцэций сум/	2015	2015	10.2	10.2
2.1.5	Нийгмийн даатгалын хэлтсийн барилгын сантехникийн болон их засвар /Сүхбаатар, Баруун-Урт сум/	2015	2015	28.3	28.3





2.1.6	Нийгмийн даатгалын хэлтсийн барилгын гадна тохижилт , хашаа хайс барих /Хөвсгөл, Мөрөн сум/	2015	2015	260.3	260.3
2.1.7	Нийгмийн даатгалын хэлтсийн барилгын их засвар /Өвөрхангай, Хархорин сум/	2015	2015	91.6	91.6
2.1.8	Нийгмийн даатгалын хэлтсийн барилгын их засвар /Дорноговь, Замын-Үүд сум/	2015	2015	60.3	60.3
2.1.9	Нийгмийн даатгалын хэлтсийн гадна тохижилт болон архивын ерөөний засвар /Орхон, Баян-Өндөр сум/	2015	2015	36.6	36.6
2.1.10	Нийгмийн даатгалын хэлтсийн гадна тохижилт /Улаанбаатар, Баянгол дүүрэг/	2015	2015	80.0	80.0
2.1.11	Нийгмийн даатгалын хэлтсийн барилгын их засвар /Дархан-Уул, Шарын гол сум/	2015	2015	35.1	35.1
2.1.12	Нийгмийн даатгалын хэлтсийн барилгын их засвар /Улаанбаатар, Багануур дүүрэг/	2015	2015	30.0	30.0
2.1.13	Нийгмийн даатгалын хэлтсийн барилгын сантехникийн их засвар /Сэлэнгэ, Сүхбаатар сум/	2015	2015	100.0	100.0
2.1.14	Нийгмийн даатгалын ерөнхий газрын цахилгаан шатны их засвар /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/	2015	2015	10.0	10.0
2.1.15	Нийгмийн даатгалын хэлтсийн гадна халаалтын их засвар	2015	2015	19.7	19.7
2.1.16	Нийгмийн даатгалын хэлтсийн конторын барилгын халаалтын засвар /Ховд, Жаргалант сум/	2015	2015	21.0	21.0



<b>3</b>	<b>III.Тоног төхөөрөмж</b>			<b>3,222.9</b>	<b>3,222.9</b>
3.1	Шинэ			3,222.9	3,222.9
3.1.1	Чанарын Удирдлагын Олон Улсын (ISO:900) стандартын хөтөлбөр /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/	2015	2015	33.0	33.0
3.1.2	Нийгмийн даатгалын үйлчилгээний цахим машин /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/	2015	2015	115.0	115.0
3.1.3	Нийгмийн даатгалын үйлчилгээний дараалал тогтоох төхөөрөмж /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/	2015	2015	30.0	30.0
3.1.4	Нийгмийн даатгалын байгууллагуудын иж бүрэн компьютер, тоног төхөөрөмж /аймаг, нийслэл/	2015	2015	1,549.4	1,549.4
3.1.5	Нийгмийн даатгалын байгууллагуудын тавилга, эд хогшил /аймаг, нийслэл/	2015	2015	850.5	850.5
3.1.6	Нийгмийн даатгалын байгууллагуудын автомашины парк шинэчлэл, сэлбэг хэрэгсэл /Улаанбаатар, Өвөрхангай, Төв, Дорноговь, Говьсүмбэр, Завхан, Сүхбаатар/	2015	2015	645.0	645.0
<b>4</b>	<b>IV.Техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв</b>			<b>366.2</b>	<b>366.2</b>
4.1	Нийгмийн даатгалын байгууллагуудын барилга байгууламжийн зураг төсөв	2015	2015	366.2	366.2



## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2014 оны 11 дүгээр  
сарын 13-ны өдөр

Дугаар 69

Улаанбаатар  
хот

### **Төрөөс мөнгөний бодлогын талаар 2015 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт, Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Төрөөс мөнгөний бодлогын талаар 2015 онд баримтлах үндсэн чиглэл”-ийг хавсралтаар баталсугай.

2.Доор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгасугай:

1/Засгийн газрын болон түүний баталгаатай гадаад өрийн эргэн төлөлттэй уялдсан төсвийн зохистой бодлого хэрэгжүүлж, төсвийн тогтвортой байдлыг хангах;

2/Засгийн газрын гадаад өрийн үйлчилгээний цогц төлөвлөгөөг 2015 оны 1 дүгээр улиралд багтаан боловсруулж хэрэгжүүлэх, гадаад валютын орох урсгалыг нэмэгдүүлэн төлбөрийн тэнцэл, улсын зээлжих зэрэглэлийг сайжруулах;

3/нийлүүлэлтийн гаралтай инфляцийг аймаг, нийслэлийн түвшинд нам, тогтвортой байлгах арга хэмжээ авах;

4/Монгол Улсын төсвийн төсөл, Монгол Улсын нэгдсэн төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөлөл боловсруулахад ашиглах төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн төсөөллийг тогтсон аргачлал, эх сурвалжид үндэслэн боловсруулах;

5/улсын гадаад өр, түүний эргэн төлөлтийн гадаад валютын ханшийн эрсдэлийг бууруулж, эрсдэлээс хамгаалах механизм бий болгох.

3.Доор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар, Монголбанк /Н.Золжаргал/, Санхүүгийн зохицуулах хороо /Д.Баярсайхан/-нд тус тус даалгасугай:

1/эдийн засгийн тогтвортой өсөлтийн суурийг бэхжүүлэх, дотоодын хуримтлалыг нэмэгдүүлэх, санхүүгийн зах зээлийн хөгжлийг дэмжих зорилгоор нийгмийн даатгал, тэтгэврийн сангийн тогтолцооны шинэчлэлийг эрчимжүүлэх, баялгийн сангийн эрх зүйн орчныг бүрдүүлэх,



хөрөнгө оруулалтын сангуудыг бий болгох, тэдгээрийг үе шаттай хөрөнгөжүүлэх;

2/2015-2017 онд санхүүгийн салбарт зээлийн тасалдал үүсэх, системийн шинжтэй тогтворгүй байдал бий болохоос сэргийлэх зорилгоор “Эдийн засгийн идэвхжлийг нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2014 оны 34 дүгээр тогтоолд заасан арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх;

3/Монголбанк, Засгийн газар хооронд макро эдийн засгийн нэгдсэн мэдээллийн тогтолцоог бий болгох, макро зохистой бодлого хэрэгжүүлэх хүрээнд төсөв, мөнгөний бодлогын уялдаа холбоог сайжруулах.

4.Төгрөгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор макро эдийн засгийн гадаад тэнцвэрийг дэмжих, банкны салбарт эрсдэл хуримтлагдахаас сэргийлэхэд чиглэсэн арга хэмжээ авахыг Монголбанк /Н.Золжаргал/-нд даалгасугай.

5.Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дунд хугацааны хөтөлбөрийг зах зээлийн зарчимд шилжүүлэх замаар иргэдийн хэрэглээний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний нийлүүлэлтийн тогтвортой тогтолцоог бий болгож, хөтөлбөрөөс үе шаттай гарах арга замыг сонгож хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар, Монголбанк /Н.Золжаргал/-нд тус тус даалгасугай.

6.Энэ тогтоолын хэрэгжилтийг зохион байгуулахыг Монгол Улсын Засгийн газар, Монголбанк /Н.Золжаргал/, Санхүүгийн зохицуулах хороо /Д.Баярсайхан/-нд тус тус даалгасугай.

7.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо /Б.Гарамгайбаатар/-нд үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

Монгол Улсын Их Хурлын 2014 оны  
69 дүгээр тогтоолын хавсралт

**ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2015 ОНД  
БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ**

Мөнгөний бодлогын үндсэн зорилт нь эдийн засгийн гадаад тэнцвэрийг хангах, инфляцийг нам, тогтвортой түвшинд байлгах,



санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх, эдийн засаг дунд, урт хугацаанд тэнцвэртэй бөгөөд тогтвортой өсөх орчныг бүрдүүлэхэд чиглэнэ.

### **1.Мөнгөний бодлогын зорилтын хүрээнд:**

1.1.Хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляцийг 2015 оны эцэст 7 хувьд, 2016-2017 онд энэ түвшинд тогтворжуулах бодлогын оновчтой хувилбарыг сонгон иргэдийн бодит орлогыг хамгаалж, эдийн засаг тогтвортой өсөх нөхцөлийг бүрдүүлнэ.

1.2.Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш нь санхүүгийн болон макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, эдийн засгийн гадаад тэнцвэрийг дэмжихүйц уян хатан тогтож, улмаар дунд хугацаанд дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, ажлын байрыг хамгаалахтай нийцтэй байх зарчим баримтална.

### **2.Банкны салбарын тогтвортой байдлыг бэхжүүлэх хүрээнд:**

2.1.Банкуудын төлбөрийн чадварыг хадгалах хүрээнд өөрийн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх замаар системийн болзошгүй эрсдэлээс хамгаалах чадварыг нэмэгдүүлж, санхүүгийн салбарын дархлааг сайжруулна.

2.2.Олон улсад мөрдөгдөж байгаа хяналт шалгалтын зарчим, зохицуулалтын арга хэрэгслийг банкны салбарын үйл ажиллагааны онцлогтой уялдуулан эрсдэлийн үнэлгээнд суурилсан хяналт шалгалтыг үргэлжлүүлнэ.

2.3.Банкны үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг төрөлжүүлэн олгох эрх зүйн орчныг сайжруулах боломжийг судалж, дотоод, гадаадын эрх бүхий байгууллагатай хамтран үр нөлөөтэй хяналт шалгалтыг боловсронгуй болгох чиглэлд ажиллана.

### **3.Санхүүгийн зах зээлийн дэд бүтэц, түүний институцийг бэхжүүлэх хүрээнд:**

3.1.Монгол Улсын төлбөр тооцооны системийн найдвартай, тасралтгүй ажиллагааг хангаж, дэвшилтэт технологид суурилсан банкны шинэлэг үйлчилгээг олон нийтэд хүртээмжтэй болгох чиглэлээр ажиллана.

3.2.Санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн банкны зах зээлд оролцогчдын эрх ашгийг хамгаалах, олон



нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх цогц арга хэмжээг эрчимжүүлнэ.

3.3. Мөнгөний бодлогын шийдвэр гаргах үйл ажиллагааг улам боловсронгуй болгон, мөнгөний бодлогын үндсэн зорилт, хэрэгжилтийг олон нийтэд тогтмол тайлагнах ажлыг үргэлжлүүлж, Төв банкны нээлттэй, ил тод байдлыг хадгална. Энэ хүрээнд инфляцийн төлөв байдлын илтгэлийг улирал бүр, санхүүгийн тогтвортой байдлын тайланг хагас жил тутам Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөр хэлэлцүүлж, Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороонд хүргүүлнэ.

3.4. Санхүүгийн зах зээлд экспортын болон давхар даатгалын оновчтой тогтолцоог бий болгох ажлыг эхлүүлнэ.

3.5. Хадгаламж, зээлийн хоршооны гишүүдийн хадгаламжийг мөнгөн хадгаламжийн даатгалд хамруулах бэлтгэл ажлыг хангана.

3.6. Тогтвортой санхүүжилтийн санаачилгыг дэмжиж ажиллана.

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2014 оны 11 дүгээр  
сарын 14-ний өдөр

Дугаар 70

Улаанбаатар  
хот

### **Монгол Улсын 2015 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6 дахь хэсэг, 25 дугаар зүйлийн 25.17 дахь хэсгийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Монгол Улсын 2015 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгасугай:

1/төрийн байгууллагын чиг үүргийн давхардал, хүнд суртлыг арилгах, иргэдэд үзүүлэх үйлчилгээг түргэн шуурхай, чанартай зохион байгуулах зарчмыг баримтлан төрийн байгууллагын бүтэц, орон тоог боловсронгуй болгох, зарим агентлаг, ажлын алба, нэгж, улсын үйлдвэрийн газар, төвийг татан буулгах, нэгтгэх саналыг холбогдох тооцоо судалгаанд үндэслэн боловсруулж, Монгол Улсын 2015 оны төсвийн тодотголын хамт 2015 оны нэгдүгээр улиралд багтаан Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;



2/Засгийн газрын тусгай сангуудыг цөөрүүлэх, сангийн хөрөнгийн удирдлага, хуваарилалт, зарцуулалт нь ил тод, үр ашигтай, санхүүгийн хувьд тогтвортой, бие даан үйл ажиллагаа явуулах боломжтой, олон улсын жишигт нийцсэн байх чиглэлээр Засгийн газрын тусгай сангийн тухай хууль тогтоомжийг боловсронгуй болгох;

3/Нийслэлийн Засаг дарга хоёр, аймаг, сум, дүүргийн Засаг дарга, Улсын Их Хурлаас удирдлага нь томилогддог байгууллага, Засгийн газрын агентлаг тус бүр нэг орлогч дарга, эсхүл дэд даргатай, орон тооны зөвлөхгүй байх, бусад бүх шатны төсвийн байгууллага орлогч дарга, эсхүл дэд дарга болон орон тооны зөвлөхгүй байхаар тооцож холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах саналыг тооцоо судалгаанд үндэслэн боловсруулж хэрэгжүүлэх, шаардлагатай бол Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

4/Ерөнхийлөгчийн болон Улсын Их Хурлын Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын удирдлага, зөвлөх, Монгол Улсын Ерөнхий сайд, Шадар сайдын ажлын алба, зөвлөх, яам, агентлаг, тэдгээрийн харьяа төсөвт байгууллагын удирдлага шатахууны зарцуулалт ихтэй жип машиныг өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэглэхгүй байх, хөдөө орон нутагт томилолтоор ажиллах тохиолдолд “Засгийн газрын авто бааз” Улсын төсөвт үйлдвэрийн газраас дуудлагын унаа захиалан хэрэглэдэг журамд шилжих;

5/төсөвт байгууллага болон төрийн өмчийн оролцоотой бүх шатны байгууллагын бичиг хэрэг, шуудан холбоо, интернетийн төлбөр, ном хэвлэл, бага үнэтэй, түргэн элэгдэх ахуйн эд зүйлс, нормын хувцас, зөөлөн эдлэл, багаж, хэрэгсэл худалдан авах зардал, хөдөлмөр хамгааллын хэрэгслийн зардал, урсгал засварын зардал, зочин төлөөлөгч хүлээн авах зардлыг 20 хувиар, эрүүл мэнд, цагдаа, батлан хамгаалах, хил хамгаалах, онцгой байдлын салбараас бусад салбарын тээвэр, шатахууны зардлыг 30 хувиар тус тус бууруулан санхүүжүүлэх;

6/Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас аймаг, нийслэлд олгох шилжүүлгийн тооцооллын аргачлалыг боловсронгуй болгож мөрдүүлэх;

7/“Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай” Монгол Улсын Их Хурлын 2014 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 30 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах арга хэмжээ авч, хэрэгжилтийн тайланг Монгол Улсын Их Хуралд 2014 оны 12 дугаар сард багтаан ирүүлэх;

8/Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр өмнөх онуудын төсвийн тухай хуулиудад тусгагдсан төсөл, арга хэмжээнүүдийг энэ онд багтаан санхүүжүүлэх арга хэмжээ авах.



2.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2016 оны төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулахдаа тэтгэмжийн зардал, зам, тээврийн салбараас бусад салбарын урсгал зардлыг 2015 оны түвшингээс нэмэгдүүлэхгүй байх зарчим баримтлахыг бүх шатны төсвийн ерөнхийлөн захирагч нарт үүрэг болгосугай.

3.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо /Ц.Даваасүрэн/-нд, хэрэгжилтийн явцыг Монгол Улсын Их Хурлын 2014 оны намрын ээлжит чуулганы завсарлагааны хугацаанд Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газарт тус тус даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**3.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

2014 оны 11 дүгээр  
сарын 21-ний өдөр

Дугаар 71

Улаанбаатар  
хот

**Монгол Улсын Ерөнхий сайдыг томилох тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 4 дүгээр зүйл, 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2 дахь хэсэг болон санал хураалтын дүнг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Ерөнхий сайдаар Чимэдийн Сайханбилэгийг томилсугай.

2.Энэ тогтоолыг 2014 оны 11 дүгээр сарын 21-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**3.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**

2014 оны 10 дугаар  
сарын 11-ний өдөр

Дугаар 326

Улаанбаатар  
хот

**Санхүүгийн алба байгуулах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:





1. Сумын Засаг даргын Тамгын газарт сумдад үйл ажиллагаа явуулж байгаа төсвийн байгууллагуудад санхүү, нягтлан бодох бүртгэлийн нэгдсэн үйлчилгээ хүргэх, сумын төсөв, санхүү, эдийн засаг, хөгжлийн бодлогын төлөвлөлт хариуцсан Санхүүгийн албыг байгуулсугай.

2. Санхүүгийн албаны зохион байгуулалт, чиг үүрэг, орон тооны жишиг нормативыг хавсралт ёсоор баталсугай.

3. Санхүүгийн алба байгуулагдсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсүгэй:

1) Суманд үйл ажиллагаа явуулж байгаа төсвийн байгууллагуудад нягтлан бодох бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх чиг үүргийг сумын Засаг даргын Тамгын газар хариуцан гүйцэтгэхтэй холбогдуулан аливаа төсөвт байгууллагуудад нягтлан бодогч давхардуулан ажиллуулахгүй байхыг бүх шатны төсвийн захирагч нарт даалгасугай.

2) 2015 оны төсвийн жилд боловсрол, эрүүл мэндийн салбарын байгууллагаас нягтлан бодогчийн орон тоо, урсгал зардлыг орон нутгийн төсөвт шилжүүлэхийг Сангийн сайд Ч.Улаан, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Гантөмөр, Эрүүл мэндийн сайд Н.Удвал нарт тус тус үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**Н.АЛТАНХУЯГ**

**САНГИЙН САЙД**

**Ч.УЛААН**

Засгийн газрын 2014 оны 326 дугаар  
тогтоолын хавсралт

**САНХҮҮГИЙН АЛБАНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,  
ЧИГ ҮҮРЭГ, ОРОН ТООНЫ ЖИШИГ НОРМАТИВ**

Нэг. Санхүүгийн албаны чиг үүргийн жишиг

1.1. Албаны дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч:

1.1.1. сумын санхүү, эдийн засаг, төсвийн бодлогыг тодорхойлж, хэрэгжилтийг зохион байгуулж, түүнд хяналт тавих;

1.1.2. санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг нэгтгэн боловсруулах;



1.1.3. орон нутгийн хөгжлийн сан, тусгай зориулалтын шилжүүлэг, сумын нэгдсэн төсвийн төлөвлөлт, хуваарилалтыг хийх;

1.1.4. төсвийн сар, улирлын хуваарийг үндэслэн төсвийн байгууллагын бүртгэлийн дансанд санхүүжилтийн болон зарцуулалтын эрх олгох;

1.1.5. төрийн сангийн гүйлгээг хянан баталгаажуулах;

1.1.6. төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлийн санхүүжилтийг холбогдох журмын дагуу санхүүжүүлэх;

1.1.7. орон нутгийн өмчийн хяналт, бүртгэлийг хэрэгжүүлэх;

1.1.8. зээл, тусламжийн хэрэгжилтийг зохион байгуулж, түүнд хяналт тавих;

1.1.9. сумын төсвийн орлого бүрдүүлэхтэй холбоотойгоор сумын татварын байцаагчийг шуурхай удирдлагаар хангаж ажиллах.

1.2. Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн:

1.2.1. төрийн сангийн үйлчилгээ үзүүлэх;

1.2.2. Засгийн газрын зарим чиг үүргийг хэрэгжүүлэх тусгай зориулалтын шилжүүлгийн нэгтгэл, хяналт;

1.2.3. төсвийн гүйцэтгэлийн мэдээг гаргах;

1.2.4. статистик мэдээллийг гаргах;

1.2.5. Аж ахуйн нэгж, байгууллагын улирал, жилийн эцсийн санхүүгийн тайланг хянаж, хүлээн авах.

1.3. Нягтлан бодогчид:

1.3.1. төсвийн орлого, зарлагын өдөр тутмын гүйлгээг хийх, бүртгэх, тайлагнах;

1.3.2. сангуудын бүртгэл хөтлөх, тайлан мэдээ гаргах;

1.3.3. орон нутгийн хөгжлийн сан, Засаг даргын нөөц хөрөнгийн бүртгэл, тайлагнал;

1.3.4. тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын төсвийн төлөвлөлт, хуваарилалтыг хийх, тэдгээрт нягтлан бодох бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх;



1.3.5. сумын төсвийн байгууллагуудын төсвийн төлөвлөлт, хуваарилалтыг хийх, тэдгээрт нягтлан бодох бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх.

1.4. Татварын байцаагч:

1.4.1. улс, орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэх;

1.4.2. татварын байцаагч нь татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад харьяалагдах бөгөөд Санхүүгийн албаны даргын шуурхай удирдлаганд ажиллана.

Хоёр. Нягтлан бодогчийн норматив

2.1. Сумын Засаг даргын Тамгын газрын Санхүүгийн алба нь дараах төсвийн байгууллагууд болон орон нутгийн хөгжлийн сан, тусгай сангууд, Засаг даргын нөөц хөрөнгийг хариуцан нягтлан бодох бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх 2 нягтлан бодогчтой байна. Үүнд:

- Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал;
- Сумын Засаг даргын Тамгын газар;
- Багийн Засаг дарга;
- Цэцэрлэг 2 хүртэл;
- Сургууль 1;
- Сумын эмнэлэг 1;
- Соёлын төв1.

2.2. Хэрэв суманд дээр дурдсанаас олон тооны төсвийн байгууллага үйл ажиллагаа явуулж байгаа бол ажлын ачааллыг харгалзан 3-5 төсвийн байгууллагын дунд 1 нягтлан бодогчтой байхаар орон тооны нормативыг тогтоох бөгөөд хариуцаж байгаа байгууллагуудын төсвийн төлөвлөлт, хуваарилалтыг хийж, тэдгээрт нягтлан бодох бүртгэлийн үйлчилгээ үзүүлнэ.

Гурав. Зохион байгуулалт

3.1. Санхүүгийн албаны дарга нь чиг үүргийн хуваарилалтыг батлагдсан орон тооны хязгаарт багтаан зохион байгуулж, мэргэжлийн удирдлагаар хангаж ажиллана.

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2014 оны 10 дугаар  
сарын 25-ны өдөр

Дугаар 350

Улаанбаатар  
хот

### Олон улсын байгууллагад гишүүнээр элсэх тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:



1. “Байгаль хамгаалах олон улсын холбоо” (International Union for Conservation of Nature)-нд гишүүнээр элсэхийг дэмжсүгэй.

2. “Олон улсын байгууллага, гэрээ, конвенцийн итгэмжит санд төлөх татвар, хандивын тухай” Засгийн газрын 2007 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 60 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Татварыг нь улсын төсвөөс төлөх олон улсын байгууллагуудын жагсаалт”-д дор дурдсан агуулга бүхий 70 дахь заалт нэмсүгэй:

“70. Байгаль хамгаалах олон улсын холбоо-БОНХЯ”.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**Н.АЛТАНХУЯГ**

**БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН  
ХӨГЖЛИЙН САЙД**

**С.ОЮУН**

### **МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**

2014 оны 10 дугаар  
сарын 25-ны өдөр

Дугаар 355

Улаанбаатар  
хот

#### **Үндэсний бахархалт цэцэг зарлах тухай**

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Бэр цэцэг”-ийг Монголын ард түмний амгалан тайван амьдрал, байгаль дэлхийг дээдлэх үзлийн бэлгэдэл болгон “Үндэсний бахархалт цэцэг”-ээр өргөмжлөн зарласугай.

2. “Үндэсний бахархалт цэцэг”-ийг олон нийтэд зарлан тунхаглах, таниулан сурталчлах ажлыг зохион байгуулахыг Соёл, спорт, аялал жуулчлалын сайд Ц.Оюунгэрэл, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд С.Оюун нарт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**Н.АЛТАНХУЯГ**

**СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ  
ЖУУЛЧЛАЛЫН САЙД**

**Ц.ОЮУНГЭРЭЛ**

#### **Хаяг:**

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакци.  
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот

И-мэйл: turin\_medeelel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 6.75

Индекс: 14003